Энэхүү файл нь БҮТ-ийн өмч бөгөөд хуулбарлаж, тараахыг хориглоно

2. Эхэд дурдсан дараах үйл явдлуудын аль нь Бэрсэд холбогдох вэ?
   A. Тэн ачаагаа татаж чангалж, тэмээдээ хэвтүүлж босгож зүтгүүлсээр.
   B. Чулуутын адгаар үхрээ туусаар уруудав.
   C. Ачлагатай тэмээдээ хөтөлсөөр толгойн энгэрээр зам дөтлөн сажилна.
   D. Хонь ямаа нийлсэн хэдэн богоо элдэх шахам туусаар тоос манан татуулж явлаа.
   E. Мориныхоо явдал дунд үсрэн буугаад, шувуудыг үргээн хашхичсаар очив.

3. "Давдаа охиноо тэвэрсэн чигээр явган суугаад, "Тайга аа... Тайга аа" хэмээн анх удаагаа бяцхан гөлгийг өөриймсөн дуудахад Тайга итгэж ядан доороо хэдэнтээ **хургаснаа** Давдаагийн өмнөөс паацганан харайв."- өгүүлбэрийн онцолсон үгийн утгыг олоорой.
   A. Шийдвэрлэж үл чадах
   B. Эрхлэн үсрэх
   C. Буцаж хоргодох, хулгах
   D. Залхуурч хоргодох
   E. Байн байн эргэх

4. Сийлэг охиноо үгүйлэх болсны учир юу вэ?
   A. Мөөмөө нэхэхгүй яасан бөх унтаа вэ гэж бодсон учраас
   B. Хөх дэлэн нь чим чим хатгуулж, халуун сүү хэвлийг нь даган урссан учраас
   C. Араг дотор зассан хэвтрээс нь охиноо авах гэтэл байгаагүй учраас
   D. Охиноо хөхүүлээд, хураалттай хөрзөнгийн нөөрт хэвтүүлж байснаа санасан учраас
   E. Энэ муу орилоо буйлангийн дуунд хүртэл сэрэхгүй байх чинь гэж бодсон учраас

5. "...хоёр муу тэмээнийх нь бөх хажуу тийш богцтой ганзагалаа мэт налмайн унжсан нь..." гэсэн өгүүлбэрийн дүрслэх ур маягийг олоорой.
   A. Ёгтлол
   B. Багасгал
   C. Амьдчилал
   D. Адилтгал
   E. Егөөдөл

6. Давдаагийн хандлага өөрчлөгдсөнийг батлах баримт аль нь вэ?
   A. Гөлөг, охин хоёроо нэгэн өвөртөө багтаагаад мордлоо.
   B. Охиныхоо эрхий дарамхан нүд нүүрийг барилан сахалтай хошуугаар энхрийлэн үнсэнэ.
   C. Нэгэнт цагийн урин хаяанд ирсэн болохоор Давдаа гөлгийг буйран дээрээ үлдээжээ.
   D. Давдаа дургүйцсэн авч дүн хүйтнээр эхээсээ хагацсан нялх амьтныг хөөж төвдсөнгүй.
   E. Гөлөг амиа тэжээгээд байж чадахуйц торнисон болохоор Давдаа гөлгийг буйран дээрээ үлдээжээ.

Энэхүү файл нь БҮТ-ийн өмч бөгөөд хуулбарлаж, тараахыг хориглоно
LIVEWORKSHEETS